

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
ХЭМЖИЛ ЗҮЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ДАРГЫН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАЖ БАЙНА.**

Нэг. Сонгон шалгаруулалтын зорилго

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 1131 дүгээр хугацаатай албан бичгийн хүрээнд Хэмжил зүйн хүрээлэнгийн даргын сул орон тоог төрийн жинхэнэ албан тушаалд тус агентлагт ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан, төрийн захиргааны албан хаагчдаас бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Сонгон шалгаруулалтын бүртгэл

Сул орон тоонд **боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар** ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тус газарт ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын материалыг төв байрны 203 “Б” (хүний нөөц), 204 ”Б” (эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн) тоот өрөөнд ажлын хэсэг **2017 оны 10 дугаар сарын 16- 18-ны өдрүүдэд 09.30-17.00** цагийн хооронд тус тус хүлээн авна.

Гурав. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн албан хаагчид дор дурдсан материалыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

Үүнд:

1. Төрийн албан хаагчийн анкет (маягт № 1);
2. Боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
3. Монгол Улсын иргэний үнэмлэх; /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/;
4. Ажилласан жилийг тооцох Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр хуудсыг хөдөлмөрийн үйл ажиллагааны хөдөлгөөнийг баталгаажуулсан бусад хуудасны хуулбар, эх хувийн хамт. /ажилласан жилийг тооцох тул хөдөлмөрийн үйл ажиллагаагаа хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн он, сар, өдрөөр нь нарийвчлан бичиж бэлтгэж ирэх/
5. Төрийн албан хаагчийн тангараг өргөсөн хуудас
6. Тухайн албан тушаалд томилогдсон тушаалын хуулбар
7. Сүүлийн 2 жилийн үр дүнгийн гэрээний илтгэх хуудас

ТАМГЫН ГАЗАР

2017.10.16

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1. Ерөнхий шаардлага:	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Дээд боловсролын бакалавр зэрэгтэй	Дээд боловсролын бакалавр зэрэгтэй
		Мэргэжил	Инженер, Байгалийн шинжлэх ухаан, Хэмжил зүйч,	Байгалийн шинжлэх ухаан болон Инженерчлэл
		Мэргэшил	Хэмжил зүйн чиглэлээр мэргэшсэн, Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн хяналтын чиглэлээр мэргэшсэн байх.	Удирдан зохион байгуулах ажил
		Туршлага	Салбартаа 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс хэмжлийн нэгжийн төрлөөр мэргэшсэн	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажиллаж байсан
	Ур чадвар	Удирдах чадвартай, Эталоныг хөгжүүлэх, сайжруулах чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулах зохих түвшний мэдлэгтэй.	Удирдан зохион байгуулах, Багаар ажиллах.	
1.2. Тусгай шаардлага: Хууль тогтоомжийг сахих, мөрдөх, өндөр ёс суртахуунтай байх, ажлын ачаалал даах оюуны болон бие бялдарын чадавхитай байх.				